

БАТЛАВ:
ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ **/Д.ЦАНЛИГРЭНЧИН/**

Огноо: **2020.03.18**

АВТОМАШИНЫ СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: ХӨАДСТӨХК/202001011/02

МӨРӨН СУМ 2020 ОН

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Хөвсгөл Дулааны Станц ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **авто машины сэлбэг хэрэгсэл**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 03-р сарын 26-ны өдрийн 10 цаг 00 минут**-аас өмнө www.tender.gov.mn цахим системээр хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 03-р сарын 26-ны өдрийн 10 цаг 10 минут** -т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх-үгүй

Тендерийн баримт бичгийг цахимаар хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50 000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

**Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, SB төвийн байр 4 давхар,
www.dulaan@khs.gov.mn
Харилцах утас: 7038-8489, 9901-9253**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жил буюу 2019 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт / 2. /Сүүлийн 1 жилийн /2019 он/ борлуулалтын дундаж хэмжээ санал болгож үнийн дүнгээс багагүй байх/ 3. Сүүлийн 1 жил /2019 он/ туршлагын мэдээлэл /ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар /2-3/, гэрээ дүгнэсэн акт хамт/ 4. Аж ахуй нэгжийн товч танилцуулга 5. Барааны жагсаалт, техникийн тодорхойлолт, үзүүлэлтийг гаргаж эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж ирүүлэх, 6. Бараан нийлүүлэлтийн хуваарь маягтын дагуу ирүүлэх 7. Ашигтай ажилласан байх-2019 он /www.tender.gov.mn Цахим сайтаас борлуулалтын орлогын хэмжээг тендерийн нээлт хийсэн өдрөөр татаж авна/ 8. Санал болгож буй барааны гарал үүслийг тодорхойлсон байх 9. НӨАТ-төлөгчийн гэрчилгээ /эх хувь/ <p>Бусад нэмэлт шаардлага; /2020 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс хойш гаргаж ирүүлэх/</p> <ol style="list-style-type: none"> 10. Шүүхийн байгууллагын тодорхойлолт /эх хувь/ 11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /эх хувь/ 12. Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тодорхойлолт <p>www.tender.gov.mn цахим сайтаас тендерийн нээлт хийх өдрийн байдлаар татаж авах баримт бичгүүдийг нийлүүлэгч ирүүлэх шаардлагагүй бөгөөд дээрхи лавлагааг тбб-ыг бүрдэлд хавсаргана.</p> <ol style="list-style-type: none"> 13. Улсын бүртгэлийн гэрчилгээ /цахим лавлагаа/ 14. Татварын тодорхойлолт /цахим лавлагаа, татварын өргүй байх/ 15. Санхүүгийн тайлан /цахим лавлагаа, тендерт оролцогчийн холбогдох чадавхын үнэлгээг хийхдээ холбогдох мэдээллийн баазаас дамжуулсан мэдээллийг үндэслэл болгоно/ <p>Жич: <i>Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно</i></p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: шаардлагагүй</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг Мөрөн сум, SB төвийн байр, 4 давхар Давхар болон өрөөний дугаар: www.tender.gov.mn цахимаар Огноо: 2020 оны 03-р сарын 26-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг Мөрөн сум, SB төвийн байр, 4 давхар Давхар болон өрөөний дугаар: www.tender.gov.mn цахимаар Огноо: 2020 оны 03-р сарын 26-ны өдөр Цаг: 10 цаг 10 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** авто машины сэлбэг хэрэгсэл
2. **Стандарт:** *Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.*
3. **Баглаа, боодол:** сав баглаа боодол бүрэн бүтэн байх
4. **Бараа хүргэх газар:** Хөвсгөл Мөрөн сум, үйлдвэрийн хашаа склад
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
	<i>Техникийн тодорхойлолтод заасан жагсаалтын дагуу</i>			<i>Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн үйлдвэрийн склад</i>	<i>Гэрээ байгуулсан өдрөөс</i>	<i>2020.12.30</i>	



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ **М.Б.** Ч. ЦОГОО

АВТО СЭЛБЭГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

"КОВШ" үйлдвэрлэсэн он -2014		
Агаар шүүгч	ш	25 хүрээ, шүүлтүүр сайнай байх
Статер	ш	1 чанартай, эдэлгээ даахуйц байх
Динам	ш	1 ороомог сайтай, эдэлгээ даахуйц байх
Донам ремен чангалагч	ш	1 шарик сайтай, хамгаалалтай байх
Дугуй	ш	2 даацын эдэлгээ даахуйц байх
Гурбин	ш	1 тосон хөргүүртэй, гол нь ган сайтай байх
Нугасан холбооны дээд доод пальц	ш	2 ган сайтай байх
Говуд	кг	40 40 градуст царцахгүй, тосолгоо сайтай байх
Говуд шилпрез	ш	1 хийгээр ажилладаг байх
Маслын шүүр	ш	2 шүүлтүүр сайн байх
Түвшний шүүр	ш	4 шүүлтүүр сайн байх
Ремен /донам/ /1350/	ш	4 чанартай байх
Аккумулятор /120 А/	ш	2 АКТЕК түүнтэй дүүцхуйц 120А байх
КАМА үйлдвэрлэсэн он-2019		
Кузовт өндөрлөгөө /4х6м2/	тег	1 засвар үйлчилгээ хийх
Дугуй /олгой хамертай дугуй/ /7-50-1/	ш	7 ANNAITE түүнтэй дүйцэхуйц байх
Салсний ремен	ш	1 чанартай байх
Ремен /донам/	ш	4 чанартай байх
Гэрэл /гом/ 24В	ш	1 тусгал сайтай байх
Гэрэл /жижиг/ 24В	ш	1 тусгал сайтай байх
Агаар шүүгч /цаасан шүүр/	ш	13 шүүлтүүр сайн байх
Гидрийн шингэн	л	20 40 градуст царцахгүй байх
АВТОБУС үйлдвэрлэсэн он -2005		
Урд тормозны планц	ш	2 чанартай, эдэлгээ даахуйц байх
Урд наклитак	ш	8 чанартай байх
Дугуй /225-80-17.5/	ш	4 HANKOOK түйтэй дүүцхуйц байх
Маслын шүүр	ш	1 шүүлтүүр сайн байх
Ремен /донам/	ш	2 чанартай, эдэлгээ даахуйц байх
Статер	ш	1 чанартай байх
Тормозны аппарат /дээд/	ш	1 чанартай, эдэлгээ даахуйц байх
Тормозны аппарат /доод/	ш	1 чанартай, эдэлгээ даахуйц байх
Амортизатор	ш	4 КУВ түйнтэй дүүцхуйц байх
Урд цапны шарик	ш	4 CTR түүнтэй дүүцхуйц чанартай байх
Тормозны шингэн	ш	2 40 градуст царцахгүй байх
Түвшний шүүр	ш	1 шүүлтүүр сайн байх
ПРИУС 20 үйлдвэрлэсэн он-2005		
Амортизатор	ш	4 КУВ түйнтэй дүүцхуйц байх
Дугуй /205-70-15/	ш	4 HANKOOK түйнтэй дүүцхуйц байх
5-н бул	хос	1 CTR түүнтэй дүүцхуйц чанартай байх

Аккумулятор /90 А/	ш	1	АКТЕК түүнтэй дүүцхүйц 120А байх
Батерей	ком	1	чанартай байх
Маслын шүүр	ш	1	шүүлтүүр сайн байх
Тормозны шингэн	ш	1	шүүлтүүр сайн байх
ПРИУС-30 үйлдвэрлэсэн он 2010			
Амразитор	ш	4	КУВ түйнтэй дүүцхүйц байх
Дугуй /өвөл/	ш	4	HANKOOK түйнтэй дүүцхүйц байх
Босоо тэнцүүлэгч	ш	2	СТР түүнтэй дүүцхүйц чанартай байх
Өндгөн тулгуур	ш	2	СТР түүнтэй дүүцхүйц чанартай байх
Масло шүүр	ш	2	шүүлтүүр сайн байх
Кропны шингэн	л	3	40 градуст царцахгүй байх
Агаар шүүгч	ш	1	шүүлтүүр сайн байх
Накладка	ш	4	чанартай байх
LAND 200- үйлдвэрлэсэн он- 2011			
Дугуй	ш	4	HANKOOK түйнтэй дүүцхүйц байх
Маслын шүүр	ш	2	шүүлтүүр сайн байх
Амразитор	ш	4	КУВ түйнтэй дүүцхүйц байх
Накладка	ш	4	чанартай байх
Кропны шингэн	ш	30	40 градуст царцахгүй байх
ХОВО үйлдвэрлэсэн он -2019			
Дугуй	ш	10	ANNAITE түүнтэй дүйцэхүйц байх
Олгой	ш	6	чанартай байх
Герман дагдий	ш	10	чанартай байх
Элгэвч хаймар	ш	6	зузаан хаймертай байх
Мэмбарам	ш	4	ган төмөр сайтай байх
Чирэгчийн накладка	хос	4	илэгдэлт багатай байх
Чиргүүлийн накладка	хос	6	илэгдэлт багатай байх
Маслын шүүр	ш	10	шүүлтүүр сайн байх
Товуд /чанар сайтай/	л	10	40 градуст царцахгүй, тосолгоо сайтай байх
Лугларам	ш	4	чанартай байх
Цисно гэрэл	ш	1	тусгал сайтай байх 24 вольт байх
ИСТАНА үйлдвэрлэсэн он-1999			
Дугуй /195-75-16S/	ш	4	чанартай байх
Амортизатор	ш	4	КУВ түйнтэй дүүцхүйц байх
Ремен /денам/	ш	3	чанартай байх
Гэрэл /урд ламп/ дотор	ш	4	тусгал сайтай байх 12 вольт байх
Гэрэл /хойд ламп/ дотор		8	тусгал сайтай байх 12 вольт байх
Дансрал /5тн/	ш	1	чанартай байх
Эн бул	хос	1	СТР түүнтэй дүүцхүйц чанартай байх
Урд наклитак	ш	4	чанартай байх
Аккумулятор /90 А/	ш	1	АКТЕК түүнтэй дүүцхүйц 120А байх
Түлхүүр /8-24/	ком	1	төмөр сайтай чанартай байх
Дорцов	ком	1	төмөр сайтай чанартай байх
Ком урл /Хурдны хайрцаг/	ш	1	чанартай, эдэлгээ даахуйц байх
Пирда диск	ш	1	чанартай байх
Муфта шарик	ш	1	шарик сайтай, хамгаалалтай байх
Маслын шүүр	ш	2	шүүлтүүр сайн байх

Цан үлээгч радиатор	ш	1	чанартай байх
Цалны шарик	ш	2	шарик сайтай, хамгаалалтай байх
Халаагч	ш	5	чанартай байх
Тормозны шингэн	ш	2	40 градуст царцахгүй байх
Агаар шүүгчийн шүүр	ш	1	шүүлтүүр сайн байх
Тулшний шүүр	ш	1	шүүлтүүр сайн байх
Шарнер /руль/	ш	2	шарик сайтай, хамгаалалтай байх

Хянасан:  Ерөнхий нягтлан бодогч В.Мөнгөнцэцэг

Боловсруулсан:  Авто механик Л.Майбаяр

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[2020.03.26]

(Хөвсгөл Дулааны станц ТӨХК)-ын дарга Д.Цанлигрэнчин танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 6 сар байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хийнэ. Урьдчилгаа төлбөр олгохгүй. Бараа тээвэрлэх зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцана. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1 Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагчаас томилсон комиссын гишүүд акт үйлдэн хүлээн авна.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 1) Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
2) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
3) Барааны гарал үүслийн гэрчилгээ
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн явцад эвдэрч гэмтсэн бараа гарсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцана.
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнийн дүнгийн **[0,1]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,1]**
Алдангийн нийт дүн: **[5]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]